Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Халзан сумын Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Алтансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 22-аас 2022 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн хариуцаж, Аудитын менежер Г.Даваа, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар чанарын хяналтыг гүйцэтгэв.

Халзан сумын Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 3-ний өдрийн 1/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төлөвлөлт ногоон хөгжлийн жил” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Ковид 19 халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эм эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн хамран сургалтыг нэмэгдүүлж боловсролын чанарт ахиц гаргах
- Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Хувийн хэвшил жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх
- Монгол үндэсний өв соёлыг цахим орчноор дамжуулан сурталчлан таниулан ажиллах

- Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, төсвийн үр ашгийг нэмэгдүүлж, сахилга батыг сайжруулах
- Өрх бүр тариаланч хөдөлгөөнийг өрнүүлж төмс хүнсний ногоо жимс жимсгэнэ тариалах иргэдийн идэвх санаачилгыг дэмжинэ.
- Малын гоц халдварт өвчнөөр тайван бүс нутаг болох
- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, цахим үйлчилгээг нэвтрүүлэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, гэмт хэрэг гаралтыг бууруулах илрүүлэлтийг нэмэгдүүлэх
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халзан сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Халзан сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагавартай байна.

Халзан сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 2,787.2 сая төгрөгийн зардлын 1.5 хувь буюу 41.8 сая, гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 31.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 154.9 сая, эцсийн үлдэгдэл 566.0 сая төгрөг болж, 411.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<i>Касст байгаа бэлэн мөнгө</i>	-	-	-	-
<i>Банканд байгаа бэлэн мөнгө</i>	3.1	8.1	5.0	1.2
<i>Төрийн сангийн харилцах</i>	151.8	519.3	367.4	92.0

Байгууллагын харилцах		12.2	12.2	2.2
Нэмэлт дансны харилцах	-	26.4	26.4	4.6
Дүн	154.9	566.0	411.1	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 519.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 26.4 сая төгрөг нэмэлт дансны харилцах дансанд, 8.1 сая төгрөг арилжааны банкны дансанд, 12.2 сая төгрөг эрүүл мэндийн төвийн харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн харилцах дансанд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого 151.1 сая, ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт 21.4 сая, төсөвт байгууллагуудын жилийн эцсийн харилцахын үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлсэн 13.1 сая, төлөвлөснөөс давсан татварын болон татварын бус орлого 333.7 сая төгрөг тус тус үлдэгдлээр үлджээ.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 135.6 сая, эцсийн үлдэгдэл 195.0 сая төгрөг болж, 59.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	0.4	125.1	124.7
Зээлийн авлага	135.2	66.9	-68.3
Дүн	135.6	195.0	59.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 66.9, Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийн авлага 117.7, засаг даргын тамгын газрын авлага 6.9, эмийн эргэлтийн сангийн авлага 0.5, ОНӨААТҮГ-ын авлага 3.0 сая төгрөгийг тус тус авлагаар тайлагнасан байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 227.9 сая, эцсийн үлдэгдэл 267.2 сая төгрөг болж, 46.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	20.7	14.4	-6.3
Эм боох материал	35.4	25.1	-10.3
Түрээсийн сурах бичиг	1.2	1.2	-
Бичиг хэргийн материал	7.0	10.4	3.4
Аж ахуйн материал	114.0	137.8	23.8
Сэлбэг хэрэгсэл	5.7	5.4	-0,3
Түлш тослох материал	3.3	2.7	-
Барилгын засварын материал	-	20.4	-20.4
Хүнсний материал	1.6	5.2	3.6
Бусад хангамжийн материал	18.3	21.9	3.6
Мал амьтад	15.4	12.4	-3.0
Нөөцийн бараа	5.3	10.4	5.1
	227.9	267.2	34.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 267.2 сая төгрөг болж 46.2 сая төгрөгөөр өссөн нь 2021 онд ковид19 өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин Эрүүл мэндийн төв, Эмийн эргэлийн сангийн эм боох материал, тусгай зориулалтын материал оны эцэст худалдан авч, нөөцөлсөн нь нөлөөлжээ. Мөн бараа материалын үлдэгдлийн 80.8 хувийг Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, ЗДТГ-ын материалын данс эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гарсан тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүйд албан шаардлага хүргүүлсэн /ЗДТГ/
- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /Эрүүл мэндийн төв/
- Бараа материалын тайланд 68,000.0 мянган төгрөгийн эмийг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, өртгөөр орлого авч тайлагнаагүйд албан шаардлага хүргүүлсэн /Эрүүл мэндийн төв/
- Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээг "Төлбөрийн цахим систем"-д шивээгдээгүй өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүйд албан шаардлага хүргүүлсэн /ЗДТГ, ОНХС Сургууль, Эрүүл мэндийн төв/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,932.9 сая, эцсийн үлдэгдэл 7,142.1 сая төгрөг болж, 235.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	2,405.7	5,401.0	2,995.3
Тээврийн хэрэгсэл	199.2	216.9	17.7
Машин тоног төхөөрөмж	457.0	535.6	78.5
Тавилга эд хогшил	333.7	347.6	14.0
Дуусаагүй барилга байгууламж	244.0	244.0	-
Номын фонд	31.3	34.8	3.5
Бусад үндсэн хөрөнгө	200.9	300.9	100.0
Программ хангамж	2.8	2.8	-
Бусад биет бус хөрөнгө	58.3	58.3	-
Дүн	3,932.9	7,142.1	3,209.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 64.2, шилжүүлэн авсан 1.0, Хүүхдийн цэцэрлэгийн, Соёлын төвийн барилга, Засаг даргын тамгын газарт хог зөөврийн машиныг үнэ төлбөргүй хүлээн авсан 3,161.9 сая, нийт 3,227.1 сая төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ИТХ-ын шийдвэрээр Онгон суманд хог зөөврийн машин шилжүүлсэн 18.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн

үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэйд зөвлөмж хүргүүлэв. /ЗДТГ, Сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, ИТХ/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 134.5 сая, эцсийн үлдэгдэл 117.9 сая төгрөг болж, 16.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	134.5	117.9	16.6
Ажилчидтай холбогдсон өглөг	6.0	-	-6.0
Байгууллага төлөх өглөг	26.2	30.7	4.5
Татварын өглөг /ТӨҮГ/	4.6	6.9	2.3
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	-	-
Дансны өглөг /ТӨҮГ/	6.7	-	-6.7
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Бусад урьдчилж орсон орлого	91.0	80.3	-10.7
Нийт дүн	134.5	117.9	-16.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгууллагад төлөх 30.7, татварын өглөг 6.9, дансны өглөг 6.7, бусад урьдчилж орсон орлого 80.3 сая нийт 117.9 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Өр төлбөр дийлэнх нь Халзан дулаан ОНӨААТҮГ үнэ төлбөргүй ирсэн 80.3 сая төгрөгийн хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэж, жил бүр капиталжуулж байгаа нь нөлөөлсөн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,208.9 сая, эцсийн үлдэгдэл 6,761.3 сая төгрөг болж, 3,552.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № .6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,512.3	2,512.3	-	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	286.7	300.1	13.4	0.8
Хуримтлагдсан үр дүн	-6.7	3,532.4	3,525.8	99.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	416.5	416.5	-	-
Дүн	3,208.8	6,761.3	3,539.2	100.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 3,525.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үед мөн хэмжээний үр дүнтэй ажилласнаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 351.1, зээлийн хүүгийн орлого 1.5, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,229.9, үндсэн үйл ажиллагааны орлого 5.4, борлуулалтын орлого 301.5, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,090.4, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 37.4, нэмэлт санхүүжилтийн орлого 283.2, орон нутгийн төсвөөс санхүүжих 1,444.9, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 12.5, төсвийн захирагчаас 6.3 сая, нийт 6,764.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

3.5.8 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 507.5 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд байна. Үүнд: ковид-19 цар тахлын зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, шуудан холбоо, бараа үйлчилгээний бусад зардал, байгаль хамгаалах сан, гамшгийн эрдлийн сан, засаг даргын нөөц сан, засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал, ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэнтэй холбоотой төсвийн урсгал зардал нэмэгдсэн бөгөөд нийт татаас санхүүжилт өссөн байна.

Зардлын данстуудтай холбоотой 11.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь төсвийг үр ашиггүй зарцуулсан цалингийн зардалтай холбоотой байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтаар нотлогдоогүй 0.3 сая төгрөгийг нөөц сангаас бэлнээр гаргасан, Засгийн газраас олгох усны үнэ 0.6 сая төгрөгийг нөөц сангаас давхардуулж олгосонд төлбөрийг акт тогтоосон /ЗДТГ/
- Коронавирус халдварын шинжилгээний төлбөр 9.8 сая төгрөгийг харилцах дансанд тушаагаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон /Эрүүл мэндийн төв/
- Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 4.5 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлдөнд төлбөрийн акт тогтоосон /Сургууль, Эрүүл мэндийн төв/
- Цалинг буруу тооцож 1.9 сая төгрөгийг олгосонд төлбөрийн акт тогтоов /Сургууль/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй 17.5 сая төгрөгийн зардал гаргасанд албан шаардлага хүргүүлсэн /ЗДТГ/
- сахилгын шийтгэл буруу ногдуулсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд цалингаас суутгасан хөлсийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн /ЗДТГ/
- Дуудлага дуудсан газрын нэр, өвчтөний оношийг дутуу бичсэн баримтаар эмч, эмнэлгийн ажилтанд илүү цагийн хөлсийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн /Эрүүл мэндийн төв/
- Илүү цагаар ажилласан тэмдэглэл хөтлөхгүй сар бүр 25 цагийг илүү цагаар ажилласнаар тооцож жолоочид 1,509.8 мянган төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн /Эрүүл мэндийн төв/
- Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй "Сумын төвийн ЦДАШ-ын засврын ажил", "Өвс бэлдэх ажил"-ыг ИТХ-аар батлуулан зарцуулсан, гүйцэтгэгч томилж хөрөнгө зарцуулах захирамж гаргахаас өмнө гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн /ОНХС/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 56.2 сая төгрөг, татварын бус орлого 4.0 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 351.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 290.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
НИЙТ ОРЛОГО	60.2	351.1	290.9
ТАТВАРЫН ОРЛОГО	56.2	343.9	287.7
Хувь хүний орлогын албан татвар	32.0	47.2	15.2
Үйл ажиллагааны орлого	1.0	0.4	-0.6
Хөрөнгийн орлого	16.0	26.0	10.0
Шууд бус орлого	15.0	20.8	5.8
Хөрөнгийн албан татвар	1.3	1.4	-0.1
Бууны албан татвар	1.3	1.4	-0.1
Бусад татвар (төлбөр, хураамж)	22.9	295.3	272.4
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	0.9	-0.6
Газрын төлбөр	1.4	0.3	-1.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	191.2	191.2
Малын тоо толгойн албан татвар	20.0	95.2	75.2
Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	7.7	7.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4.0	7.2	3.2
Хүү, торгуулийн орлого	4.0	1.9	-2.1
Бусад орлого	-	5.3	5.3

Орон нутгийн татварын орлого 287.7 сая, татварын бус орлого 3.2 сая, нийт 290.9 сая төгрөгөөр давсан байна. Шууд бус орлого давж орсон нь арьс шир, ноосны урамшуулал 5.8 сая, сумын харьяалал бүхийг иргэн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татвар 7.7 сая, татварын байцаагч “малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу 443 малтай өрхөөс 95.2 сая төгрөгийн татварын орлогыг бүрдүүлэхээр төлөвлөж, сумын ИТХ-д танилцуулсан ч төлөөлөгч нар 20.0 сая төгрөгөөр баталснаас орлого давж биелсэн байна. Мөн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн дагуу тус сумын нутаг дэвсгэрээс 7 ширхэг шонхор шувуу барьсны төлбөр 191.1 сая төгрөгийн төлөвлөөгүй орлого төвлөрсөн нь орлого давах гол шалтгаан болжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 онд татварын орлогыг 56.2 сая, татварын бус орлогыг 4.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,117.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,928.9 сая төгрөгийг урсгал зардалд, 69.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, сум хөгжүүлэх сангийн зээлд 119.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 12.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 120.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 5.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны

орлогоос санхүүжих 834.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,090.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 18.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалаас, 37.4 сая төгрөгийг ОНХСангаас олгох орлогын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 69.8 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас, 5.9 сая туслах үйл ажиллагааны орлогоос, 791.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,085.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 12.4 сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 37.4 сая төгрөгийг ОНХСанд олгох орлогын шилжүүлэг нийт 2,002.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 115,5 сая төгрөгөөр хөтөлбөр арга хэмжээ дутуу санхүүжигдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,911.2 сая төгрөг буюу 90.2 хувьтай байгаа нь төсвийн зарцуулаагүй хэмнэлттэй холбоотой байна.

Нэмэлт төсөв:

Ковид-19 цар тахлын хүрээнд хандив тусламж 6.0 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 25.5, сая дээд шатны төсвийн захирагчаас 250.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8.5 сая нийт 290.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин, НДШ-ын зардалд 58.5 сая, байр ашиглалттай холбоотой зардалд 14.9 сая, хангамжийн бараа материал 34.4 сая, норматив зардалд 56.9 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 36.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, бараа үйлчилгээний бусад зардалд 13.3 сая, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 8.5 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 40.3 сая, нийт 263.4 сая төгрөгийг зарцуулж, эрүүл мэндийн төвийн үлдэгдэл 26.4 сая төгрөгийг тухайн байгууллагын харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар засаг даргын нэгтгэсэн тайланд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Халзан сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 3 тусгайн сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 10 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, дүгнэлт өгч, 1 байгууллага хязгаарлалтай, 2 байгууллага, 3 орон нутгийн тусгай сан нийт 5 газрыг түүвэрт хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 806.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 17.3 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 134.4 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 651.2 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Халзан сумын Засаг даргын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд татвар ба татварын бус орлогыг үнэн зөв төлөвлөх, засаг даргын хөтөлбөрийн зардлыг мөрийн хөтөлбөртэй уялдуулж төлөвлөсөн байдлыг дараагийн аудитаар авч үзэхээр төлөвлөв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 47.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, нэг асуудалд зөвлөмж өгч, нэг албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулаа.

Засаг даргад хүргүүлсэн албан шаардлага

4.1.1 Иргэдээс санал авч, эрэмбэлээгүй 17,380.0 мянган төгрөгийн /"Сумын төвийн ЦДАШ-ын засварын ажил", "Өвс бэлтгэх ажил"/ төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6/ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй ,орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд хөрөнгийг зарцуулахгүй байх/ заалт Сангийн сайдын 2021 оны 86 тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.2 /ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр , төсөл арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх/ заалттай нийцэхгүй байна.

4.1.2 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-т заасан хэрэглэгчийн системтэй этгээдээс худалдан авалт хийсэн боловч 29,880.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг хавсаргаагүй, ebarimt системд бүртгэлгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 /албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ/ заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн : Албан шаардлага хүргүүлэв.

4.2. Сахилгын шийтгэл тооцуулах тухай

ОНХС-ийн зөрчилтэй холбоотой төсвийн төвлөрүүлэн захирагч буюу засаг даргад хариуцлага тооцуулах албан шаардлагыг дээд шатны төсөв захирагчид хүргүүлэв.

5. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

5.1 Татварын орлоготой холбоотой асуудал:

Илрүүлэлт:

5.1.1 Тус сумын татварын байцаагч "Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл, Сумын ИТХ –ын төлөөлөгчдийн 2021 оны А/03 дугаар тогтоолын дагуу 95.2 сая төгрөгийн албан татвар төлөвлөж, ИТХ-д танилцуулсныг сумын ИТХ-ын төлөөлөгч нар тухай жилд 20.0 сая төгрөгөөр баталжээ.

5.1.2 Эрсдэл: Төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх, хуулийг хэрэгжүүлээгүй.

5.1.3 Өгсөн зөвлөмж:

Сумын ИТХ-ын төлөөлөгч нар “ Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл, “Төсвийн тухай хууль”-ийн 60 дугаар зүйлийн 60.2.8/малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна/ заалт, -Д заасны дагуу Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу орлогыг ИТХ-аар баталж, зарцуулах.

5.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:

4.2.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.2.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.3.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2022-3-24	Аудитын нэр:	Халзан сумын Засаг даргын 2021оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: СБА-2022/10/НА-СТА-ТТ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Халзан сумын засаг даргын санхүүгийн нэгдсэн тайлан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй "Сумын төвийн ЦДАШ-ын засварын ажил", "Өвс бэлдэх ажил"-ыг ИТХ-аар батлуулан зарцуулсан, гүйцэтгэгч томилж хөрөнгө зарцуулах захирамж гаргахаас өмнө гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн	17.3	Албан шаардлага	Засаг дарга Санхүү төрийн сангийн албаны дарга	Г.Алтансүх О.Туяа
2	"Төлбөрийн цахим систем"-д нийт 29,880.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний төлбөр ebarimt шивэгдээгүй	29.8	Албан шаардлага	Засаг дарга Санхүү төрийн сангийн албаны дарга	Г.Алтансүх О.Туяа
3	"Ахуйн үйлчилгээний засварын ажил" гүйцэтгэх гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн боловч гэрээ дүгнээгүй, хүлээн авах комисс байгуулах захирамж гаргаагүй	-	Сахилгын шийтгэл ноогдуулах	Аймгийн засаг дарга	М.Идэрбат
Дүн		47.1			